

ГАРЧИГ

I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
II. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	5
III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
IV. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ЗОРИЛТ	8
V. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	9
VI. ОРЧНЫ ТОХИЖИЛТ ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
VII. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
VIII. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
IX. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	28
X. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	29
XI. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	31
Зураг 1. Үйлдвэрийн бүсийн фото зураг	2
Зураг 2. Түүхий эдийн агуулах	4
Зураг 3. Химийн бодис, түүхий эдийн агуулах.....	10
Зураг 4. Авто тээврийн засварын шоф, тээврийн хэрэгсэлд зорчхх санамж.....	10
Зураг 5. Зам усалгаа, замын тэмдэглэгээ.....	12
Зураг 6. Үйлдвэр, агуулахын бүс дэх хог хаягдлын сав.....	13
Зураг 7. Авто машины зогсоол, ахуйн хог хаягдал байршуулах хэсэг нь үерийн далан, шуудуунаас зайтай байрладаг	15
Зураг 8. Мод тарих өдөрлөг	16
Зураг 9. Мод усалгаа	17
Зураг 10. Галын дүгнэлт	20
Зураг 11. Гал унтраах хэрэгслийн үзлэг, шинэчлэлт	21
Зураг 12. Галын дүгнэлт	21
Зураг 13. Химийн бодис тээвэрлэх маршрут.....	22
Зураг 14. Гал унтраах хэрэгсэл ашиглах дадлага	22
Зураг 15. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ	23
Зураг 16. 2024 оны гамшгаас хамгаалах төлөвлөгөө.....	23
Зураг 17. Химийн бодисын агуулахад үзлэг хийх явц.....	24
Зураг 18. Ахуйн хог хаягдал шилжүүлэх гэрээ	26
Зураг 19. Хог хагядлыг ангилах дотоод журам	27
Зураг 20. Түмэн эгшиг ХХК гэрээ	27
Зураг 22. Ажлын хувцас хэрэгсл, НБХХ.....	30
Зураг 22. Эрүүл мэндийн үзлэг	30
Хүснэгт 1. Төслийн хэрэгжиж буй талбайн байрзүйн солбилцол	2
Хүснэгт 2. Эмульс бэлтгэх хэсгийн үндсэн тоног төхөөрөмжийн үзүүлэлт	3

I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төсөл хэрэгжүүлэгч:

“МЕРА” ХХК

Төслийн нэр:

Тэсрэх бодисын үйлдвэрлэл, агуулах

Улсын бүртгэлийн дугаар: 9011108011

Регистрийн дугаар: 2619687

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

Монгол улс-210644, Улаанбаатар хот | Сити Тауэр /17 давхарт/, Чингис хааны нэрэмжит талбай 1, 8-р хороо Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар, Монгол улс, 14200 **Утас:** 75 55 66 77 **Факс:** 11 319276 |

Төслийн байршил:

Өмнөговь аймгийн Гурвантэс сумаас урагш 22 км, "Саусгоби Сэндс" ХХК-ийн Наран жаргах ил уурхайгаас 3,5 км зайд тэсэлгээний ажлыг гүйцэтгэх зорилгоор уурхайн дэргэд, эмульсийн тэсрэх бодисын үл тэсрэх хольцын үйлдвэрийг 2020 онд байгуулсан ба Сумын Засаг даргын 2010 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн а/116 тоот шийдвэрийн дагуу “Майга” уулын зүүн хойно дараах газруудыг 15 жилийн хугацаатай эзэмшдэг. Өөрийн эзэмшлийн 2,7 км сайжруулсан авто замтай.

Хүснэгт 1. Төслийн хэрэгжиж буй талбайн байр зүйн солбицол

Нэр	Талбай	У	Х
Үйлдвэр, агуулах	4 га	42.976278	101.178702
		42.976358	101.178686
		42.975031	101.175761
		42.975083	101.175575



Зураг 1. Үйлдвэрийн бүсийн фото зураг

МЕРА ХХК нь “Саусгоби Сэндс” уурхайн дэргэд үйлдвэрлэлийн зориулалт бүхий Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр”-ийг барьж 2020 онд ашиглалтад оруулсан.

Эмульсийг тусгай зориулалтын цэнэглэгч машинд ачаалан зөөж, уурхайн тэсэлгээний блок дахь цооногуудыг цэнэглэнэ. Цэнэглэгч машин нь эмульс болон эмульсийн тэсрэх бодис үйлдвэрлэхэд шаардагдах үл тэсрэх нэгдлүүдийг тус тусад нь ачиж, тэсэлгээний блокт очих бөгөөд цооног цэнэглэх явцад тэдгээр нь холигдон, цооногт орсноос хойш 5-10 минутын дараа тэсрэх бодис байдлаар цооногт цэнэглэгдэнэ.

Эмульсийн үйлдвэр жилд 365 /Жилийн 300 хоногт нь тэсрэх бодисоо үйлдвэрлэдэг, 65 хоногт нь засвар үйлчилгээ хийдэг/ ажлын өдөр, хоногт 2 ээлжээр ажилласан тохиолдолд 22,5 мян.тн шингэн эмульсийн тэсрэх бодис үйлдвэрлэх боломжтой.

Үйлдвэрийн бүтээгдэхүүн нь задгайгаар нийлүүлэгдэх ба Австрали улсын дэвшилтэт техник технологи бүхий энэхүү шингэн тэсрэх бодис нь Сибирийн нөхцөлд тохирсон буюу -40°C-өөс +40°C температуртай орчинд найдвартай ажиллах боломжтой.

Тоног төхөөрөмж:

Хүснэгт 2. Эмульс бэлтгэх хэсгийн үндсэн тоног төхөөрөмжийн үзүүлэлт

№	Тодорхойлолт	Хэмжих нэгж	Үзүүлэлт
Эмульсийн матрикс бэлтгэх төхөөрөмж			
1	Багтаамж	м ³	6000
2	Хутгуурын хөдөлгүүрийн чадал	кВт	1,5
3	Дотоод диаметр	мм	50
4	Шахуургын даралт	МПа	1,28
5	Цахилгаан халаагуурын чадал	кВт	4
6	Холих арга	агаараар	
ENT-2600			
1	Багтаамж	кг	26000
2	Диаметр	мм	2940
3	Гангийн өндөр	мм	4300
4	Хөдөлгүүрийн чадал	кВт	27
5	Тоо ширхэг	ш	2
Нийт цахилгаан зарцуулалт		кВт	388,3

Шингэн тэсрэх бодис үйлдвэрлэх технологи:

Шингэн эмульсийн тэсрэх бодис нь исэлдүүлэгч уусал буюу усан фаз, тосон фазын холимгоос үүсэх шингэн эмульс, сэвсгэржүүлсэн аммиакийн шүү, хийжүүлэгч нэмэгдэл гэсэн үндсэн 3 хольцоос бүрдэнэ

Исэлдүүлэгч усан уусмалыг аммиакийн шүү, ус, натрийн карбонат, цууны хүчил, тиомочевин болон мочецин бодисуудыг технологийн дагуу батлагдсан орцын хэмжээгээр хольж уусгах замаар үүсгэнэ.

Дизель түлшээр ажилладаг генератор ашиглан усыг халааж уусмал бэлтгэх сав руу цутгасны дараа усны хэмжээнд тохируулан аммонийн нитратыг бага багаар нэмнэ.

Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрлэлийн технологийн шаардлагад тохирсон усан уусмалыг эмульс бэлтгэх төхөөрөмж рүү фильтрээр шүүж насосоор шахна. Цууны хүчил ашиглан уусмалын орчныг тохируулна.

Түлшний нөөцийн савнаас насосын тусламжтайгаар шахагдан ирсэн дикелт түлш нь тасалгаа дахь тензодатчик болон хутгуураар тоноглогдсон саванд эмульгатортой холилдон тосон фазыг үүсгэнэ.

Исэлдүүлэгч усан уусмал болон тосон фазыг технологийн орц найрлагын дагуу хольж найруулсан бүтээгдэхүүнийг эмульсийн матриц гэнэ.

Эмульсийн матрицад шилэн бөмбөлгөөр тэсрэмтгий болгох болон хийжүүлэх, хатууруулах нэмэгдлийг хийснээр үйлдвэрийн эцсийн бүтээгдэхүүн эмульсийн тэсрэх бодис бий болно.



Зураг 2. Түүхий эдийн агуулах

II. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Физик газарзүй.

Хүрэн шандын нүүрсний ордыг түшиглэн байгуулсан тэсрэх бодисын үйлдвэр агуулахын орчмын нутаг дэвсгэр нь нам уулс, жижиг толгод, талархаг гадаргуу зонхилох бөгөөд дтд 1490-1590 м өргөгдсөн. Тэсрэх бодисын үйлдвэрийн талбай нь Гурвантэс сумын төвөөс урагш 22.5 км зайтай байрладаг. Монгол орны ландшафтын мужлалаар Алтайн өвөр говийн цөлийн тойрог, Алашань говийн тойрог болон Говь Алтайн уулын цөлөрхөг хээрийн тойргийн заагт хамаарагдана.

Цаг уур, уур амьсгал.

Үйлдвэрийн орчмын нутаг дэвсгэр нь чийг багатай, хуурай дулаавтар мужид багтдаг, агаар ба хөрсний температурын хоногийн хэлбэлзэл ихтэй, хур тунадас бага учраас нэлээд хуурайшилттай, салхи шуурга ихтэй, улирал нь огцом солигддог онцлогтой. Эмulsionийн үл тэсрэх хольцын үйлдвэр орчмын уур амьсгал нь эх газрын эрс тэс, нэн хуурай, дулаан хээрговийн уур амьсгалын ангилалд багтана. Говийн уур амьсгалын эрс тэс шинж нь хаврын дулааралт, намрын сэрүүсэлтийн явц ижил, зундаа халуун-хуурай, өвөл харьцангуй дулаавтар, хавар салхи шуургатай, хаврын эхэнд жаварлаг, хаврын сүүл рүү нэн хуурайшил ихтэй байдгаас хамаарна. Жилийн дулаан үе нь 29/III-28/V хүртэл 219 хоног үргэлжилдэг нь манай орны хойд хэсгээс 30-40 хоногоор илүү байна. Энэ нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, хөдөлмөрийн нөхцөлд эерэг нөлөө үзүүлдэг. Дулаан улирлыг 3 үе болгон хувааж үзэхэд эхэн 33 хоног, дунд үе 149 хоног, сүүл үе 31 хоног, нийт 213 хоног болж байна.

Жилийн хүйтэн үе нь 28/X-29/III-ний хооронд 146 хоног үргэлжилж байгаа нь өвөл харьцангуй богино болдгийг харуулна. Хүйтэн улирлыг 3 үе болгон хуваавал эхэн үе 35 хоног, харин дунд үе 81 хоног, сүүл үе 36 хоног буюу нийт 152 хоног болох ба 81 хоногт нь дүн өвөл болдог байна. Гурвантэс сум орчмын нутагт хур тунадас бага ордог. Олон жилийн дундаж нийлбэр хэмжээгээр 122 мм тунадас унасны 85-90% нь дулааны улиралд хур бороогоор, үлдсэн нь цас хэлбэртэй хүйтэн улиралд ордог. Салхи шуурга нь говь, тал нутагт их хүчтэй, ноёлох чиглэл нь тод илэрдэг бөгөөд орчны бохирдол, тоос шороо зөөгддөг онцлогтой. 1989-2017 оны цаг уурын мэдээллийн дагуу жилийн дундаж салхины хурд 4.5-5.0 м/с байна. Өвөл, хавар, намрын улиралд баруун өмнөд чиглэлийн салхи зонхилж, харин зун баруун өмнөдийн салхины давтагдал багасаж зүүн хойд болон хойд зүгийн салхины давтагдал нэмэгдэж ирдэг онцлогтой.

Гадаргын болон газар доорхи ус.

Төслийн талбайд гадаргуугийн усан сүлжээ харьцангуй сул хөгжсөн. Байнгын урсгалтай гол, горхи байдаггүй, цөөн тооны булаг, шандтай. Эдгээр нь бороо ихтэй жил усны түвшин ундарга ихсэх ба гандуу хуурайшилттай жилүүдэд ус нь багасаж, зарим нь газрын гүнд шургах, ширгэх төлөв байдалтай.

Говийн боржингийн бүрдлийн янз бүрийн хэсэгт өрөмдсөн цооногуудын газрын доорх усны хатуулаг нь 6-13мг/экв-н хооронд хэлбэлздэг бөгөөд эрдэсжилт ихтэй ус юм. Энэ ус нь ундны усны шаардлагыг хангадаггүй. Ус агуулагч доод давхарга (Q2) ул суурийн үндсэн чулуулаг дээр оршдог. Давхаргын зузаан 100-150м. Ус агуулагч дээд давхарга 50м байх бөгөөд зарим хэсэгт энэ давхарга угаагдаж үгүй болдог.

Хөрсөн бүрхэвч.

Төсөл хэрэгжих талбай орчимд говийн бор хөрсний хэв шинжид багтах 3 төрлийн хөрс тохиолдоно:

Цөлөрхөг хээрийн чулуутай бор хөрс. Майга улааны хойт хөндийд дтд 1100-1200 м өндөрт, делювийн нунтаг карбонатлаг хурдас дээр тархана. Цөлөрхөг хээрийн чулуутай бор хөрсний ялзмагт үеийн зузаан дунджаар 0-16 см, хөрсний өнгөн үе том жижиг чулуутай. Ялзмагийн хуримтлал дээд үедээ 0.65%, нийт азот хөрсний бүх үе давхаргуудад 0.03%, хөрсний урвалын орчин рН 8.94 буюу сулавтар шүлтлэг, 100г хөрсөнд шингээгдсэн сууриудын нийлбэр 24.0 мг/экв, хөдөлгөөнт фосфор 1.98 мг, солилцох кали 7.3 мг.

Цөлөрхөг хээрийн сул хөгжилтэй бор хөрс. Ухаа гүвээ толгодын хоорондох нарийвтар хөндийгөөр тархах бөгөөд цөлөрхөг хээрийн чулуутай бор хөрстэй ерөнхийдөө адил боловч ургамлан нөмрөг, шим тэжээлийн бодисын агууламжаараа арай дутмаг байдаг онцлогтой. Ийм хөрс агуулахын хашааны дунд хэсэг, зүүн урд хэсгээр элюви-делювийн хурдас дээр тархана. Ялзмагийн үе давхаргагүй, өнгөн үе чулуу ихтэй, эоловийн элсээр хучигдсан байна.

Цөлөрхөг хээрийн үйрмэг чулуутай бор хөрс. Гарал үүслээрээ дээрх хөрсний төрлүүдтэй адилаар, зөвхөн газрын гадарга дээр тархсан чулууны хэмжээ /том, жижиг/ гадаргын байдлаараа өөр байдаг.

Ургамлан нөмрөг.

Ургамлын бүлгэмийн хувьд монгол өвс (*Stipa gobica*), таана (*Allium polyrrhizum*), бор бударгана (*Salsola passerina*), улаан бударгана (*Reamuria soongarica*), түнтгэр баглуур (*Anabasis brevifolia*), гялгар дэрс (*Achnatherum splendens*), шар бударгана (*Kalidium foliatum*), сибирь хармаг (*Nitraria sibirica*), зүүн гарын хазаар өвс (*Cleistogenes soongarica*), хөмүүл (*Allium mongolicum*), төлөгчдүү бор таар (*Ajania nelillous*), орог тэсэг (*Eurato ceratoides*) зэрэг ургамлууд бүрдүүлж байна. Үүний дотроос монгол өвс-таанат бүлгэмдэл, монгол өвс-баглуурт бүлгэмдэл, монгол өвс-бор бударганат бүлгэмдэл, бор бударгана-улаан бударганат бүлгэмдэл, шар бударгана-улаан бударгана-бор бударганат бүлгэмдэл, дэрст бүлгэмдэл, сибирь хармагт бүлгэмдэл зонхилно.

Амьтны аймаг.

Өмнөд говийн энэхүү байгаль орчин нь экосистем, ландшафтын өвөрмөц тогтоц бүхий нутаг бөгөөд энэхүү өвөрмөц орчинг шүтэн амьдардаг сээр нуруутан болон сээр

нуруугүйтэн амьтад цөөнгүй байдаг. Төслийн талбай орчимд нийт 48 төрлийн амьтад оршин байгаагаас 31 төрлийн хөхтөн, 11 төрлийн шувуу, 6 төрлийн мөлхөгч зонхилон тархсан байна. Эдгээрээс ховордож болзошгүй бүлэгт багтах амьтад нь хөхтөн амьтдаас Хярс, Шар үнэг, Саарал чоно, Сануул, Монгол хулан, Цагаа зээр болон Аргаль; шувууны ангиас Загийн бор шувуу, мөлхөгчдийн ангиас нарийн могой байна.

Геологийн тогтоц

Төсөл хэрэгжих талбай орчмын нутаг дэвсгэр нь геологийн тогтцын хувьд карбоны вулканоген-тунамал хурдас, хожуу карбон-доод пермийн вулканоген чулуулаг, харин төв хэсэгт нь дээд пермийн нүүрс агуулагч хурдас зонхилон тархсан ба хэсэг хэсэг жижиг талбайд юра, цэрд, палеоген, неогены настай тунамал, туфоген-тунамал, терриген хурдсууд тааралдана.

Нийгэм-Эдийн засаг.

Гурвантэс сум нь засаг захиргааны анхан шатны нэгж болох 5 багтай. Сумын эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй, уул уурхай. Сумаас 55 км-т орших Дундголын давсны уурхайгаас “Говь гурван сайхан ХХК”, “Асралт ХХК”, “Сондог нөхөрлөл” нь жилдээ 220 орчим тн давс олборлож борлуулдаг ба сумаас 25 км-т орших Чин-Хуа Мак, Мак, Нарийн сухайт ХХК, Монголын алт МАК ХХК, Саусгоби сэндс ХХК, Өсөх зоос ХХК, Жавхлант орд ХХК-ууд нүүрс олборлон БНХАУ-д экспортолж байгаа бөгөөд Алтны АГМ майнинг ХХК, хайрганы Чухамжаргалан ХХК, чулууны Баатарван транс ХХК, Өмнийн говийн баялаг ХХК үйл ажиллагаа явуулж байна.

Сумын хэмжээний томоохон бүтээн байгуулалтуудаас дурдвал: Сум дотроо 7 км хатуу хучилттай зам, замын гэрэлтүүлэг, уурын зуух шинээр барьсан, цэвэрлэх байгууламжийг барьж байгуулсан, сумын хэмжээний хувийг цэвэр бохир, дулааны шугамыг асуудлыг шийдвэрлэсэн, сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлсэн, удирдлагын ордон, соёлын төв, ЕБС-ийн спорт заал, цагдаагийн тасгийн байрыг тус тус шинээр барьж ашиглалтад оруулсан төдийгүй цэцэрлэгт хүрээлэнгүүдийг барьж ашиглалтад оруулаад байна.

III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Түүхий эд болон бэлэн болсон бүтээгдэхүүнийг ачиж буулгах, тээвэрлэх явцад агуулах, үйлдвэр, барилга байгууламж орчмын хөрс элэгдэх, эвдрэх, агаарт тоос дэгдэх, хог хаягдал, түүхий эдийг ил задгай хаяснаас хөрсний бохирдол үүсэх, автомашины хөдөлгөөнөөс үүдэн зам орчмын ургамлан бүрхэвчид нарийн ширхэгт тоос тогтож улмаар ургалтад нь сөргөөр нөлөөлөх зэргээр тэсрэх бодисын үл тэсрэх хольцын үйлдвэрийн төслөөс байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх боломжтой. Гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн дэлгэрэнгүй тодорхойлолт, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, зарцуулагдах зардлын хэмжээг тодорхойлов.

IV. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ЗОРИЛТ

“МЕРА” ХХК нь энгийн тэсрэх бодис, задгай болон савласан эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл хамгийн бага түвшинд байлгахыг 2024 онд зорилт болгон ажиллаж байна.

- Монгол улсын Үндсэн хууль болон бусад байгаль орчинтой холбоотой хууль, дүрэм журам, стандартуудын хүрээнд үйл ажиллагаа явуулна.
- Байгалийн нөөц баялгийг ариг гамтай ашиглаж, үйл ажиллагаанаас бий болсон хоёрдогч түүхий эд, материалыг зүй зохистой ашиглах ба дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.
- Сум орон нутгийн байгууллагатай байгаль орчин, нийгмийн хүрээнд хамтран ажиллаж, төслийн үйл ажиллагааг нээлттэй байлгана.
- “Байгаль орчны менежментийн тогтолцоо, шаардлага, хэрэглэх арга зүйн заавар MNS ISO 14001:2016” стандартын хэрэгжилтийн нийцтэй байдлын талаарх магадлах гадаад аудитыг хийлгэж, байгальд сөрөг нөлөөлөл багатай техник, технологиор үйл ажиллагаагаа явуулж, учирч болзошгүй эрсдэлүүдийг байнгын хяналтдаа байлгана.
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний сайжруулалтыг хийж, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг тодорхойлно.
- Үйл ажиллагааны процессуудын эрсдэлийн тодорхойлж, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.

V. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Гүйцэтгэл
Агаар орчны сөрөг нөлөөллийг бууруулах							
1	Дотоод болон гадаад орчны агаарын бохирдол	Төсөл орчмоос гарч байгаа дуу чимээг стандартын түвшинд байлгах, давсан тохиолдолд эх үүсвэрийг тодорхойлж, багасгах арга хэмжээ авах	Төслийн хэмжээнд	Дотоод зардлаар		2024 онд	Хөдөлмөрлөх орчны нөхцөлд хийсэн шинжилгээгээр үйлдвэрлэлийн орчин, ажлын байран дахь шуугиан стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд гэж гарсан. Шаардлагатай үед хэрэглэх сонсгол хамгаалах хэрэгслийг бэлэн байлгаж байна.
2		Тэсэлгээний бодисыг халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэрээс хол, нарны гэрэл шууд тусахааргүй нөхцөлд, зориулалтын сав баглаа боодол, контейнерт хадгалах.	Төслийн хэмжээнд	Дотоод төлөвлөлтөөр		Тогтмол	Тэсрэх бодис тэсэлгээний хэрэгслийг цахилгаан эх үүсвэр, нарны шууд тусгал тусахааргүй тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм болон бусад хууль тогтоомжийн шаардлагыг хангасан агуулахад хадгалж байна. Химийн бодис – 3, Шүүний- 1, хэрэгслийн-8 агуулах үйлдвэрийн бүсэд байна. <i>Зураг-3</i>
3		Бүх тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм, техникийг тогтмол үзлэгт хамруулах, засвар үйлчилгээ хийх. Агаарын бохирдлын төлбөр төлөх	Төслийн хэмжээнд	Дотоод хяналтаар		Тогтмол	Салбарын хэмжээнд ашиглаж байгаа бүх тээврийн хэрэгслийг жилд нэг удаа, аюултай ачаа тээвэрлэдэг тээврийн хэрэгслийг жилд 2 удаа улсын үзлэгт хамруулж техникийн бэлэн байдал, аюулгүй байдалд анхаарч ажиллаж байна. Агаар бохирдуулсны төлбөрийг тухайн жилийн 2 сард татварын албанд тогтмол төлдөг. <i>Зураг-4</i>
Нийт зардал					₮ 0		

Зураг 3. Химийн бодис, түүхий эдийн агуулах



Зураг 4. Авто тээврийн засварын шоф, тээврийн хэрэгсэлд зорчхх санамж



ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН ОРЧНЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ							
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Гүйцэтгэл
1	Газрын гадарга, хөрсөн бүрхэвчийн доройтол	Хөрсний мониторинг судалгааг мэргэжлийн байгууллагаар жилд 1-2 удаа хийлгэж, үр дагаврыг тогтмол хянах	Үйлдвэрийн талбайд	ОХШХ-т тусгав.		Жилд 1-2 удаа	ОХШХ-т тусгав.
2	Тээврийн хэрэгсэл, машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор зам засвар арчилгаа, усалгаа хийх	Төслийн хэмжээнд	₮ 760,000.00	₮ 0.00	Жил бүр 2 удаа	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор үйлдвэр, агуулахын бүс рүү орох чиглэлийн замыг хусаж, сул шороог цэвэрлэдэг. Тоосжилт ихтэй үед замын усалгааг хийсэн.
3		Тээврийн хэрэгслийн зорчих хэсгийн замыг тэмдэг тэмдэглэгээтэй болгох	Авто, зогсоол, зам талбайн хэмжээнд	Дотоод зардлаар		Тогтмол	Үйлдвэр, агуулахын бүсийн авто тээврийн хөдөлгөөний хэсэг болон зогсоолд чиглэлийн болон бусад тэмдэг тэмдэглэгээ байршуулж мөрдүүлдэг. Мөн тээврийн хэрэгсэл бүрд тээврийн хэрэгсэлд зорчих үед мөрдөх санамжийг байршуулсан.
4	Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг ил задгай хаяснаар хөрс бохирдох	Үйлдвэрийн эдэлбэр газрыг тогтмол цэвэрлэж байх, шороон шуурга салхины нөлөөгөөр гаднаас элдэв хог, хатсан ургамал зэрэг шатаж болзошгүй хог хаягдал орж ирэхээс сэргийлэх, орж ирсэн тохиолдолд зайлуулах.	Эдэлбэр газрын хэмжээнд			Төсөл хэрэгжих хугацаанд	Төслийн хэмжээнд ахуйн хог хаягдлын ангиан хаях хогийн савуудыг байршуулж ажилчдыг тогтмол мэдээллээр хангаж ажилладаг. Хог хаягдлын савны тэмдэг тэмдэглэгээг шинэчлэн сайжруулсан.
5		Хог хаягдлын сав, цэгийн тохижилт, засвар үйлчилгээг тогтмол хийх	“Мера ХХК”	₮ 1,400,000.00	₮ 0.00	Улирал тутам	Хог хаягдлын савыг гарын доорх материалаар хийж эдэлгээ сайтай, хаягдлыг ангилж хийхэд хялбар байдлаар шийдэж байршуулсан.

6	Химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглахтай холбогдон гарах нөлөөлөл	Бүх төрлийн химийн бодис, шатамхай шингэнийг халаалтын хэрэгсэл, системээс хол нарны гэрэл шууд тусахааргүй, үер усанд автахааргүй нөхцөлд хадгалах	Төслийн хэмжээнд			Үйл ажиллагааны туршид	Тэсрэх бодис тэсэлгээний хэрэгслийг цахилгаан эх үүсвэр, нарны шууд тусгал тусахааргүй тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм болон бусад хууль тогтоомжийн шаардлагыг хангасан агуулахад хадгалж байна.
7		Тэсэлгээний бодис, материал хүлээн авах талбай, агуулах, үйлдвэрийн барилга байгууламж, шал зэрэгт байнгын үзлэг шалгалт хийж, эвдрэл гэмтэл гарсныг засварлах	Төслийн хэмжээнд			Үйл ажиллагааны туршид	Ажлын байрны үзлэг хийх хуваарийн дагуу тогтмол хяналт үзлэг хийж үл тохирлыг цаг тухай бүрд нь арилгаж ажилласан.
	Нийт зардал			₮ 2,160,000.00	₮ 0.00		



Зураг 5. Зам усалгаа, замын тэмдэглэгээ



Зураг 6. Үйлдвэр, агуулахын бүс дэх хог хаягдлын сав

УСАН ОРЧНЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ							
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Гүйцэтгэл
1	Бараа материалын тээвэр хийх хүнд машин механизмын хөдөлгөөнөөр үүссэн бохирдол болон хог хаягдал нь үерийн усаар зөөгдөх	Ахуйн хуурай хог хаягдлын цэг болон шингэн хаягдлыг зайлуулах цэг, машин техникийн зогсоол зэргийг жалга, суваг шуудуунаас хол зайд байрлуулах	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардлаар		Тогтмол	Ахуйн хуурай хог хаягдлын цэг болон шингэн хаягдлыг зайлуулах цэг, машин техникийн зогсоол зэргийг жалга, суваг шуудуунаас хол зайд байрлуулдаг. Ахуйн хог хаягдлын хуримтлал үүсгэлгүй тухай бүрд нь гэрээт байгууллагаар ачуулдаг.
2	Тэсэлгээний хорт болон аюултай бодисыг хүлээн авах, тээвэрлэх, хадгалах, түгээх, хэрэглэх үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс бодис алдагдаж, гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулах	Төслийн үйлдвэр болон агуулах орчмын үерийн хамгаалалт, даланд үзлэг шалгалт хийж, засварлаж байх	Төслийн хэмжээнд	₮ 200,000.00	₮ 0	2024 онд	Үйлдвэр, агуулахын гэнэтийн халдлага, гал, үерээс хамгаалах далан шуудуунуудад улирал бүр үзлэг шалгалт хийж, засварлах, хог хаягдлыг нь цэвэрлүүлэх ажлыг хийж гүйцэтгэдэг
	Нийт зардал			₮ 200,000.00	₮ 0.00		



Зураг 7. Авто машины зогсоол, ахуйн хог хаягдал байршуулах хэсэг нь үерийн далан, шуудуунаас зайтай байрладаг

Ургамлан бүрхэвчийг хамгаалах арга хэмжээ							
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Гүйцэтгэл
1	Ургамлан нөмрөгийн устал, талхагдал	Үйлдвэрийн талбай доторх хатуу хучилт бүхий талбайг хагарч цуурах, эвдрэх зэргээс сэргийлэх, эвдэрсэн тохиолдолд засаж янзлах ажлыг гүйцэтгэх	Үйлдвэрийн талбай болон орчны бүсэд			Үйл ажиллагааны турш	Үйлдвэр агуулахын бүсийн зам талбайд тогтмол үзлэг хийдэг. Авто замын эвдрэл байхгүй.
2		Үйлдвэрийн талбай дотор ургамал ургах нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, ургасан тохиолдолд цэвэрлэж байх.	Төслийн талбайд	₮ 50,000.00		Үйл ажиллагааны турш	Үйлдвэр агуулахын дотоод бүсэд ургамлан бүрхэвч байхгүй.
	Нийт зардал			₮ 50,000.00	₮ 0.00		

VI. ОРЧНЫ ТОХИЖИЛТ ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /ш/	Төсөвлөсөн зардал (төгрөг)	Зарцуулсан зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Гүйцэтгэл
1	Төсөл хэрэгжих газар байгаль, цаг уурын онцлогт тохируулан үйлдвэрийн хашаан дотор мод тарьж ногоон байгууламжийг өргөтгөх байгуулах	Мод тарих /Хайлаас, буйлс, улиас/	Ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарих	Үрсэлгээ /Суулгацын тоо/	250	₮ 25*9,000 2,250,000	₮693,750	2024 онд	ГТС-аас баруун тийш 3км-т сумын БО-ноос олгосон газарт 250 ш заг мод тарьсан.
Нийт зардал						₮ 693,750			

ГТС-аас баруун тийш 3км-т сумын байгаль орчны мэргэжилтнээс зөвлөсөн газарт 250ш заг модыг суулгаж, арчилгаа усалгааг тогтмол хийж байна.



Зураг 8. Мод тарих өдөрлөг



Зураг 9. Мод усалгаа

ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Гүйцэтгэл
1	Тэсрэх бодисын үйлдвэр нь газрын хэвлий ухах, ашигт малтмалын үйл ажиллагаа явуулахгүй тул түүх, соёлын өвд олдох, өртөхгүй	Төслийн талбайн хэмжээнд түүх соёлын өв олдсон тохиолдолд орон нутгийн төрийн байгууллагатай хамтран ажиллах	Төслийн нийт эдэлбэр газрын хүрээнд	Дотоод зардлаар	2024 онд	“ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР”-ийн үйл ажиллагаанд хамаарах талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар болон археологийн болон палеонтологийн олдвор олдсон тохиолдол бүртгэгдээгүй.

VII. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Төсөвлөсөн зардал (төгрөг)	Зарцуулсан зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Гүйцэтгэл
1	Галын аюул, гамшиг осол	Төслийн объектын галын аюулгүй байдлын дүгнэлт, гэрчилгээг холбогдох мэргэжлийн албаар гаргуулж тухайн дүгнэлтийн дагуу гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх	Төслийн хүрээнд	-		₮ 150,000.00	Тухайн жилд	Галын аюулгүй байдлын дүгнэлтийг холбогдох мэргэжлийн албаар гаргуулсан ба дүгнэлтийн дагуух зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажилладаг
2		Төслийн байгууламжийг анхан шатны галын аюулын эсрэг хэрэгслээр холбогдох норм журмыг баримтлан хангах /галын хор, элс, ус нөөцлөх сав гэх мэт/. Галын аюулын эсрэг хэрэглэх материалыг шинэчлэн солих/галын хорын ашиглах хугацаанаас хамаарч, анхааруулгын самбар, гал гарах үед хэрэглэх багаж хэрэгсэл/.	Үйлдвэрийн хэмжээнд	10 ш	₮ 130,000.00	₮ 1,300,000.00	Үйл ажиллагааны туршид	Галын сарайны хөрөө, жоотуу зэргийг шинэчилж тавьсан. 7ш галын сарайны иж бүрдлийг гүйцээсэн.
3		Ажилчдад галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх сургалт зэрэг зохион байгуулалт хийх	Үйлдвэрийн хэмжээнд	-	₮ 500,000.00	₮ 0.00	Жилд 1 удаа	Онцгой байдлын газартай хамтарч галын аюулаас сэргийлэх, гал унтраах хэрэгсэл ашиглах сургалт, дадлага орсон
4		Гамшиг, ослын байдлыг хязгаарлах төлөвлөгөөг ажилчдад таниулж сургах ба сургалтын протокол хөтөлж баримтжуулах	Зохион байгуулах	-	-	-	Жилд 2 удаа	Гамшиг, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан, баримталж ажиллаж байна.

5		Төслийн үйл ажиллагааны явцад галын аюул, гамшгийн эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх.	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ	-	₮ 2,500,000.00	₮	3 жилд 1	2023 онд хийлгэсэн.
6	Химийн бодистой ажиллахад үүсэх осол эрсдэл	Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтын хатуу чанга дэглэм баримтлан ажиллах	Үйлдвэрийн үйл ажиллагаа болон тээвэрлэлтийн маршрут	-	-	-	Үйл ажиллагааны туршид	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмыг баримтлан батлагдсан маршрутын дагуу тээвэрлэлтийг хийж, химийн бодисын ХАЛМ-д заасан шаардлагыг хангах нөхцөлд хадгалалтыг хийж гүйцэтгэж байна.
7		Химийн бодисын тээвэрлэлтийг зориулалтын тээврийн хэрэгслээр гүйцэтгэх	Химийн бодис тээвэрлэх маршрут	-	-	-	Үйл ажиллагааны туршид	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам, аюултай ачаа тээвэрлэх стандартуудыг хангах тээврийн хэрэгслээр тээвэрлэлт хийгдэж байна.
8		Химийн бодисын сав баглаа боодлыг тогтмол шалгах	Төслийн хүрээнд	-	-	-	Шатамхай, онцгой хортой бодисын сав баглаа боодлыг өдөрт 1 удаа	Хуваарийн дагуу үзлэгийг тогтмол хийдэг.
	Нийт зардал				₮ 4,300,000.00	₮ 1,450,000.00		



**ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ДҮГНЭЛТ**

Дугаар 0007274

"МЭРА" ХХК

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр:

Холг: **ӨМНӨГОВЬ АЙМАГ, ГУРВАНТЭС СУМ,**

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл:

"ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХ"

Барилга байгууламжид газ унтраах тэнгэр тохооромж, газ унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж анхны шатны багаж хэрэгсэл, бодис материалыг эргийн байрлуулсан шингэхэд илүү дүгнэлтийг олгоно.
Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 19 дүгээр зүйлийн 19.2.

Олгосон: 2024 03 25 он сар өдөр
Хүчинтэй хугацаа: 2025 03 25 он сар өдөр хүртэл

ӨМНӨГОВЬ Дүгнэлт олгосон Огноо байдлын газар /хэлтсийн/
дарга **ХУРАНДАА** аймаг, нийслэлийн Огноо байдлын газар /хэлтсийн/
цолтой **М.АДЬЯАБААТАР**

ӨМНӨГОВЬ Дүгнэлт олгосон Огноо байдлын газар /хэлтсийн/
Гал түймрийн үлсэн хяналтын байцаагч **АХМАД** цолтой **Б.НАРАНЦАЦРАЛ**

Тэмдэг дарна



**ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ДҮГНЭЛТ**

Дугаар 0007273

"МЭРА" ХХК

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр:

Холг: **ӨМНӨГОВЬ АЙМАГ, ГУРВАНТЭС СУМ,**

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл:

"Б ТӨРЛИЙН ШАТАХУУН ТҮГЭЭХ СТАНЦ"

Барилга байгууламжид газ унтраах тэнгэр тохооромж, газ унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж анхны шатны багаж хэрэгсэл, бодис материалыг эргийн байрлуулсан шингэхэд илүү дүгнэлтийг олгоно.
Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 19 дүгээр зүйлийн 19.2.

Олгосон: 2024 03 25 он сар өдөр
Хүчинтэй хугацаа: 2025 03 25 он сар өдөр хүртэл

ӨМНӨГОВЬ Дүгнэлт олгосон Огноо байдлын газар /хэлтсийн/
дарга **ХУРАНДАА** аймаг, нийслэлийн Огноо байдлын газар /хэлтсийн/
цолтой **М.АДЬЯАБААТАР**

ӨМНӨГОВЬ Дүгнэлт олгосон Огноо байдлын газар /хэлтсийн/
Гал түймрийн үлсэн хяналтын байцаагч **АХМАД** цолтой **Б.НАРАНЦАЦРАЛ**

Тэмдэг дарна

Зураг 10. Галын дүгнэлт

**ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ДҮГНЭЛТ**

Дугаар 0007275

"МЭРА" ХХК

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: _____

Хаяг: **ӨМНӨГОВЬ АЙМАГ, ГУРВАНТЭС СУМ,**

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл: _____

"ХИЙМИЙН БОДИСЫН АГУУЛАХ"

Барилга байгууламжаа гал унтраах тоног төхөөрөмж, гал унтраах автомаш бэлэн,
дохиоллын систем, утас зийгуулах систем, усан хангамж, анхны ялгавч багаж хэрэгсэл,
бодис мийсрүүх, тэргийг байрлуулан ашиглахад зохих дүгнэлтийг олгоно.

Галын аюулгүй байдлын гухай зуулын 6 дугаар зүйлийн 6.1.3, 49 дүгээр зүйлийн 19.2

Олгосон: 2024 03 25 он сар ваар
2025 03 25 он сар ваар

Хүчинтэй хугацаа: он сар өдөр хүртэл

ӨМНӨГОВЬ Дүгнэлт олгоогч байрлал, хэргийн үйлдлийн газар /хэлтсийн/
дэргэ **ХУРАНДАА** дотой **М.АДЪЯАБААТАР**

ӨМНӨГОВЬ Дүгнэлт олгоогч байрлал, хэргийн үйлдлийн газар /хэлтсийн/
дэргэ **АХМАД** дотой **Б.НАРАНЦАЦРАЛ**

Гал зүймрийн үлсын хяналтын байрлал

Зураг 12. Галын дүгнэлт



Зураг 11. Гал унтраах хэрэгслийн үзлэг, шинэчлэлт



Зураг 14. Гал унтраах хэрэгсэл ашиглах дадлага

2024 оны БОМТ-ын тайлан

БАТЛАВ:
БҮРТГЭЛ ХЯНАЛТЫН ТӨВИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.НАРАНБААТАР


2024 оны ... сарын ... өдөр

ЗӨВШӨӨРӨВ:
МЭРАХХК-ийн НИЙЛҮҮЛЭЛТ,
ЛОГИСТИКИЙН МЕНЕЖЕР

Б.ХОНГОРЗУЛ

2024 оны 06 сарын 12 өдөр

Тус компанийн 2024 оны 06-р сарын 12-ны өдрийн № 02/728 тоот дурдсан маршрут баглуулах хүсэлтийг хүргүүлээ.




- ★ - Ачаа ачиж газар
 - ★ - Ачаа буулгах газар
 - 🚚 - Хооллох газар
 - 🚚 - Хооллох газар
 - 🚚 - Түлш цэнэглэх газар
 - 🚚 - Хоноглох газар
 - 🚚 - Холбоо барих газар
- ➡️ Хагуу хучагтай зам – 105км ➡️ Ердийн хөрсөн зам – 310км


№	Эхлэх	Очих	Зай км	Хугацаа	Тайлбар
1	Өмнөговь аймгийн Цогтцшир сумын нутаг дахь "МЭРА" ХХК-ийн Таван толгой салбар	Өмнөговь аймгийн Даламзадгал сум	131	119 минут	Хооллох газар

ЗӨВХӨН ЗӨВШӨӨРСӨН МАРШРУТЫН ДАГУУ ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОНО.

Зураг 13. Химийн бодис тээвэрлэх маршрут



Зураг 16. 2024 оны гамшгаас хамгаалах төлөвлөгөө



Зураг 15. Гамигийн эрсдэлийн үнэлгээ



Зураг 17. Химийн бодисын агуулахад үзлэг хийх явц

VIII. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Төсөвлөсн ө өртөг, сая.төг	Зарцуулсан зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Гүйцэтгэл
Хөрс, ус, агаарын бохирдол. Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх	Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, зайлуулах, дахин ашиглах тогтолцоог нэвтрүүлэх	Үйлдвэрийн хэмжээнд	550,000₮	4,900,000₮	Тухайн жилд	Ахуйн хог хаягдлыг ангилах дотоод журмын дагуу ангилан ялгаж хуримтлал үүсгэлгүй гэрээт “Хайртын босго” ХХК-гаар тээвэрлүүлж байна.
	Ахуйн хог хаягдлыг цуглуулж хог хаягдал зайлуулах гэрээний дагуу зайлуулж байх	Үйлдвэрийн хэмжээнд			Тухайн жилд	
	Ашигласан химийн бодисын сав баглаа боодлыг ашиглалтын дараа цуглуулж химийн бодис нийлүүлэгчид буцаан тушаах эсхүл эрх бүхий байгууллагын удирдамжийн дагуу аюулгүй газарт хадгалах	Ашигласан материалын уут сав, олгой, таар, шуудай гэх. мэт	Үйл ажиллагааны зардал		Үйл ажиллагааны туршид	Ашигласан химийн сав баглаа боодлыг аюулгүй зориулалтын газарт хадгалдаг ба хог хаягдлыг “Түмэн эгшиг ХХК”-д гэрээний дагуу шилжүүлэн устгуулдаг.
	Химийн бодисын сав баглаа, хаягдлыг их хэмжээгээр хуримтлуулж удаан хугацаагаар хадгалахгүй байх, үйлдвэрээс зохих журмын дагуу материалыг бүрдүүлж хаягдлыг устгуулах тухай хүсэлтийг гаргаж	“МЭРА” ХХК-ийн хэмжээнд			Үйл ажиллагаа эрхлэх бүх хугацаанд	Химийн бодисын сав баглаа боодлыг хуримтлал үүсгэлгүй, тээвэрлэлтийн эрх бүхий авто машинаар, гэрээт байгууллага болон “Түмэн эгшиг” ХХК-д хүргэж ажиллаж байна.
	Ахуйн хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, салхинд хийсэж тарахаас сэргийлэх		250,000₮	0₮	Тухайн жилд	
	Хаягдал тос масло цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуй нэгж, байгууллагатай хийсэн гэрээний дагуу хаягдал тос маслог нийлүүлэх		700,000₮	0₮	Тухайн жилд	
	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ				4,900,000₮	

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2024 оны 01 сарын 04 өдөр

№ 05

Гурвантэс сум

Энэхүү Ажил Гүйцэтгэх Гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн 343 дугаар зүйлийн холбогдох хэсгийг ҮНДЭСЛЭН:

Нэг талаас 3635163 регистрийн дугаартай "Хайртын боого" ХХК (цаашид "Гүйцэтгэгч" гэнэ)-г төлөөлж, Захирал Б.Мөнх-Очир, нөгөө талаас 2619687 тоот регистрийн дугаартай "Мера" ХХК (цаашид "Захиалагч" гэнэ) ийг төлөөлж, Т16 үйлдвэрийн инженер В.Хишигбуян нар, (цаашид "Талууд" гэх) дор дурьдсан нөхцлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. Гэрээний зорилго

1.1 Энэхүү гэрээний үндсэн зорилго нь Гүйцэтгэгч нь Захиалагч талын үйл ажиллагаанд шаардлагатай ажлыг хийж гүйцэтгэх, Захиалагч нь гэрээний үнийг төлөх харилцаанд талуудын эдлэх эрх, үүрэг, хүлээх хариуцлага, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах болон маргаан шийдвэрлэхтэй холбогдох харилцааг зохицуулна.

ХОЁР. Гүйцэтгэх ажил

- 1.1 Гүйцэтгэгч нь захиалагчийн Овоот толгой уурхай дахь Парк, Түлш цэнгэлэх талбай дахь хогийн цэгээ хуурай хог хаягдлыг ачиж, Саусгоби сэнс ХХК-ийн кемпийн хогийн цэгт ангилан хаях ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 2.2 Талууд энэхүү гэрээний дагуу ажиллахдаа Монгол Улсын хууль тогтоомж болон гэрээний заалт бүрийг дагаж мөрдөнө.
- 2.3 Гэрээт хугацаанд 7 хоногт 1 удаа захиалагчийн хог хаягдлыг тээвэрлэнэ.

ГУРАВ. Гэрээний төлбөр

- 3.1 Гэрээний нийт төлбөр: 550,000 /таван зуун тавин мянга / төгрөг байна.
- 3.2 Дээрх үнэд НӨАТ 50000/тавин мянга/ төгрөг орсон.
- 3.3 Сар бүрийн 20-ны өдөр Захиалагчийн имэйл хаягруу Гүйцэтгэгч тал өмнөх сарын нэхэмжлэхийг явуулна.
- 3.4 Захиалагч нэхэмжлэхийг хүлээн авснаас ажлын 5 хоногийн дотор Гүйцэтгэгчийн Төрийн банкны 210000507275 тоот дансанд төлбөрийг шилжүүлнэ.
- 3.5 Гүйцэтгэгч тал И баримтыг нэхэмжлэх илгээсэн өдөр шивэх үүрэгтэй.
- 3.6 Хог хаягдлын хэмжээнээс үл хамаарч сарын төлбөр тооцогдоно.

ДӨРӨВ. Талуудын эрх үүрэг

- 4.1 Гүйцэтгэгч тал нь гэрээнд заасан ажлыг чанартай хийж гүйцэтгэх.
- 4.2 Захиалагч тал нь гэрээнд заасны дагуу төлбөрийг төлөх.
- 4.3 Захиалагч тал өөрийн хогийн цэгт хуурай хог хаягдлыг хуванцар сав болон бусад гэсэн ангилалаар ангилж хадгалах үүрэгтэй.
- 4.4 Захиалагч нь гэрээний гүйцэтгэлтэй холбоотой санал, хүсэлт гаргах шийдвэрлүүлэх эрхтэй.

ТАВ. Талуудын хүлээх хариуцлага

- 5.1 Гүйцэтгэгч тал нь хуваарийн дагуу ажлыг гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс хасаж тооцно
- 5.2 Гүйцэтгэгч тал ажлыг хангалттай гүйцэтгээгүй тохиолдолд өөрийн зардлаар ажлыг дахин хийж гүйцэтгэнэ.
- 5.3 Энэхүү гэрээ талуудын гарын үсэг зурж тамга дарснаар хүчин төгөлдөр болно.
- 5.4 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах талаар талууд харилцан тохиролцож бичгээр шийдвэрлэнэ.

ЗУРГАА. Гэрээний хугацаа

6.1 хугацаа: 2024 оны 01-р сарын 04-ний өдрөөс 2024 оны 12-р сарын 31-ны өдрийг дуустал 12 сарын хугацаатай байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛ:

ЗАХИАЛАГЧ ТАЛ:

Захирал: Б.Мөнх-Очир
Хаяг: Өмнөговь аймаг,
Гурвантэс сум, Урт баг,
Цохионо ус, 7-9 тоот
Утас: 99157712

Т16 үйлдвэрийн инженер: Т.Алтанхуяг
Хаяг: Сити Тауэр бизнес төв, Сүхбаатарын
талбай 8/1, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Улаанбаатар хот 14200, Монгол Улс
Утас: 75556677, 99124922

Гарын үсэг



Гарын үсэг



Зураг 18. Ахуйн хог хаягдал шилжүүлэх гэрээ

	ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАХ, ХАДГАЛАХ, УСТГАХ ЖУРАМ	ХАБЭАБО	
		Код: МЖ1-11	Хуудас: 7
Хянасан дугаар: 2	Хянаж өөрчилсөн бүлэг, заалт: Стандартын дагуу шинэчилсэн	Огноо: 2014.12.22 2018.01.12	
Мөрдөөж эхлэх: 2018.01.15	Хариуцагч: ХАБЭАБО-ны хэлтэс		
Баталсан:	Гүйцэтгэх захирал: Г.Бүжин		
Хянасан:	ХАБЭАБО-ны ахлах менежер: В.Ундрах-Эрдэм		

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. “Хог хаягдлыг ангилах, хадгалах, устгах журам” нь Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO 14001:2005 стандарт, Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344:2011 стандарт, Хог хаягдлын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Тээвэрч дэлбэрэх бодис, тээвэлгээний хэрэгслийн эргэлтэд хянаж тавих тухай хуулийг үндэслэн боловсруулагдана.

ХОЁР. ЗОРИУЛАЛТ

2.1. МЭРА ХХК-ийн Таван толгой салбар, Т11 үйлдвэрийн үйл ажиллагааны хүрээнд гарсан хог хаягдлыг анхан шатанд ангилан ялгах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах, дахин боловсруулах боломжтой хаягдлыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид гэрээгээр нийлүүлэхтэй холбогдсон хариуцаж зохицуулахад зориулагдана.

ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ

3.1. Тээрэх бодисын Т11, Т12 үйлдвэрийн агуулахын нутаг дэвсгэр, ажигчдын амрах байр, түүний орчин тойрон, гэрээт компанийн түр кемп, ажлын талбаруудыг хамарна.

ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ.

4.1 “ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал” /цаашид хог хаягдал/ - хэрэглээний болон үйлдвэрлэл, үйлчилгээний явцад үүсч, цаашид тухайн зориулалтаар хэрэглэгдэхгүй болсон эд юмс

4.2 “ердийн хог хаягдал” - айл өрхөөс гарах хог хаягдал болон түүнтэй найрлага, бүтцийн хувьд ижил хог хаягдал

4.3 “аюултай хог хаягдал” - хүн, амьтан, ургамлыг өвчлүүлэх, гэмтээх, тэдгээрийн үр удамд хор хөнөөл учруулах болон байгаль орчны хэвийн төлөв байдалд сөрөг нөлөөтэй хортой, идэмхий, исэлдүүлэгч, шатамхай, дэлбэрэх аюултай, цацраг идэвхтэй, халдвартай шинж чанартай хатуу, шингэн, хийн хэлбэрийн хог хаягдал

4.4 “дахивар” - дахин ашиглах боломжтой хаягдлуудын ерөнхий нэршил ба доорх хэлбэрээр хуваагдана. Үүнш:

- Цаасан - цаас, сонин, сэтгүүл, дэвтэр, бичгийн цаас, төрөл бүрийн сав баглаа, боодлын цаас, картон цаас г.м
- Хуванцар - ус, ундаа, хоол амтлагч, ургамлын тос, гоо сайхны болон ахуйн цэвэрлэгээний бүтээгдэхүүний хуванцар савнууд
- Галгар уут
- Резин - бүх төрлийн дугуйн хаймар болон бусад резинэн хог
- Шилэн - хүнсний бүтээгдэхүүний болон ундааны шилэн сав

МЭРА ХХК-ийн ХАБЭАБО

Хуучин 1/7

Зураг 19. Хог хаягдлыг ангилах дотоод журам



2023 оны 04 сарын 05-ны өдөр

Гэрээ №. 2023/04

Улаанбаатар хот

Нэг талаас Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 14-р хороо, Намьянжү-44 “Түмэн-Эгшин” ХХК, Үйлдвэр эрхэлсэн ерөнхий менежер албан тушаалтай Батмөнх овогтой Олбаяр /цаашид “Хүлээн авагч” гэх/, Нөгөө талаас Монгол улс, Улаанбаатар хот-14200, Сүхбаатар дүүрэг 8-р хороо, Сүхбаатарыг талбай-1, Сити тауэр, 17-р давхарт “МЭРА” ХХК (регистрийн дугаар: 2619687)-ийг төлөөлж Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны хэлтсийн дарга албан тушаалтай Буенсүрэн овогтой Цогбадрах /цаашид “Шилжүүлэгч” гэх/ нар Шилжүүлэгчийн үйл ажиллагааны явцад гарсан химийн бодисууд үлдэгдлийг хадгалах байгууламжинд шилжүүлэхээр харилцан тохиролцож энэхүү гэрээг доорхи нөхцлөөр байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Гэрээ байгуулагч талууд нь 2017 онд шинэчлэн батлагдсан “ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ” Монгол Улсын хууль, холбогдох дүрэм, журмыг удирдлага болгон энэхүү гэрээг байгуулсан ба үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.
- 1.2 Шилжүүлэгчийн зүгээс Хүлээн авагчдад энэхүү гэрээгээр чанарын шаардлага хангахааргүй болсон химийн бодис, сав баглаа боодлын хаягдал (цаашид “хог хаягдал” гэх) шилжүүлснээр Хүлээн авагч нь химийн бодисын хаягдлыг аюулгүй байгууламжинд хадгалж, цаашид ахуйн эргэлтэнд оруулахгүй байх үүрэг хүлээнэ.

ХОЁР. ХҮЛЭЭН АВАГЧИЙГ ЭРХ, ҮҮРЭГ.

- 2.1 Хүлээн авагч нь энэхүү гэрээний 1.1-д заасан хууль тогтоомж, дундаа Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 сарын 23-ны өдрийн 54/А, 136/А/215 дугаар бүхий хамтарсан тушаалаар баталсан “ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИС ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, АШИГЛАХ, УСТГАХ ЖУРАМ”-ыг мөрдлөгөө болгон ажиллана.
- 2.2 Хүлээн авагч нь химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгахтай холбоотой холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авсан байна.
- 2.3 Химийн бодисын хаягдал, бохирдсон хөрс, шороо бүхий хаягдлын агуулах, талбайд байршуулах, саармагжуулах, шатаах, устгах зорилгоор Шилжүүлэгч талаас хүлээн авснаар тухайн хаягдлын хувьд бүхий л хариуцлагыг хүлээх үүрэгтэй.
- 2.4 Аюултай хаягдлыг өмчлөх эрх, хариуцлагыг шилжүүлэн авсан тухайгаа аюултай хаягдлын улсын бүртгэлд бүртгүүлнэ.
- 2.5 Устгасан тухай протоколыг 2 хувь үйлдэж 2 талын гарын үсэг зурж 1 хувийг шилжүүлэгч талд, нөгөө хувийг өөртөө архивлан авч үлднэ.
- 2.6 Аюултай хаягдал тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, битүүмжилсэн, зориулалтын тээврийн хэрэгсэлээр хаягдлыг тээвэрлэнэ.
- 2.7 Хүлээн авагч тал нь химийн бодисын хаягдлыг тээвэрлэх, ачааг буулгах ажлыг бүрэн хариуцна.
- 2.8 Хүлээн авагчийн буруутай үйл ажиллагаанаас болж гуравдагч этгээдэд хохирол учирсан тохиолдолд хүлээн авагч хохирлыг бүрэн хариуцаж төлж барагдуулах үүрэгтэй.

Зураг 20. Түмэн эгшиг ХХК гэрээ

IX. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Төлөвлөсөн зардал (төгрөг)	Зарцуулсан зардал, төг	Тайлбар	Гүйцэтгэл
1	Хөрсний хүнд металлын үзүүлэлтээр	Үйлдвэр, агуулах орчмын хөрсний 4 цэг	Жилд 1 удаа	400,000₮	300,000	Төслийн талбайн хөрс бохирдуулагч бодисууд болон хүнд металлын хэмжээ бохирдлыг тодорхойлох	Шинжилгээний сорьц бэлтгэх зааврын дагуу мониторингийн цэгүүдээс сорьцыг бэлтгэж. Лабораторид хүргэсэн. Шинжилгээний хариу хүлээгдэж байна.
2	Ус, хүнд металл, химийн үзүүлэлтээр	Ундны ус, хаягдал ус	Жилд 1 удаа	200,000₮	150,000	Төслийн талбайд ашиглагдаж буй ундны болон хаягдал усан дахь хүнд металлын хэмжээг тодорхойлох	Шинжилгээний сорьц бэлтгэх зааврын дагуу мониторингийн цэгүүдээс сорьцыг бэлтгэж. Лабораторид хүргэсэн. Шинжилгээний хариу хүлээгдэж байна.
3	Агаар орчны шинжилгээ	Үйлдвэр, агуулах орчмын агаарын 4 цэг	Жилд 1-2 удаа	200,000₮	198,000	Төслийн талбайн агаар дахь бохирдуулагч, дуу чимээний хэмжээг тодорхойлох	Шинжилгээний сорьц бэлтгэх зааврын дагуу мониторингийн цэгүүдээс сорьцыг бэлтгэж. Лабораторид хүргэсэн. Шинжилгээний хариу хүлээгдэж байна.
Нийт зардал				800,000,00₮	648,000		

**Х. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа	Урьдчилан тооцсон төсөв	Зарцуулсан зардал	Хариуцсан албан тушаалтан	Гүйцэтгэл
1	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох дүүргийн байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Үйл ажиллагааны турш	Үйл ажиллагааны турш	-		Салбарын дарга, БО-ны мэргэжилтэн	Харьяа аймаг, сумын байгаль орчны албатай хамтран ажиллаж хүсэлт, албан бичгийг хүлээн авч мэдээ, материалыг цаг тухай бүрт нь илгээж ажиллаж байна.
2	Байгаль орчны аудит хийлгэх	Төслийн хэмжээнд	2 жилд 1 удаа	₮ 7,000,000.00	₮ 10,000,000.00	Байгаль орчны мэргэжилтэн	Байгаль орчны аудит хийх тусгай зөвшөөрөлтэй компани болох “Мархал Тал” ХХК-аар салбарын байгаль орчны аудитыг хийлгэж байна.
3	Ажилтнуудыг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Үйлдвэрийн ажилтнууд	2024 онд	Нэг хүний ₮ 280,000.00	₮ 6,600,000.00	Салбарын дарга	Бүх ажилчдыг ХАБЭА-н тухай хууль болон эрүүл мэндийн сайдын 340 тушаалын хүрээнд эрүүл мэндийн хугацаат үзлэгт тогтмол хамруулдаг. 2024 онд Сонмедикал болон 4-р эмнэлэгт ажилчдыг эрүүл мэндийн багц үзлэгт хамруулсан.
4	Үйлдвэрийн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулж, хамруулах	Үйл ажиллагааны турш	Жилд 2 удаа	-	-	Салбарын дарга, БО-ны мэргэжилтэн	Салбарын сургалтын эрх бүхий мэргэжилтэн тогтмол зохион байгуулж ажилчдыг хамруулдаг.
5	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг хийлгэх	-	2024 онд	₮ 6,000,000.00	-	Салбарын дарга	ГТБЧХБ хийх эрх бүхий байгууллага сонгогдсон бөгөөд, ГТБЧХБ хийх шаардлагатай хугацаанд хээрийн ажил хийгдэж амжаагүй тул ирэх онд үргэлжлэн хийгдэх болсон.

6	Хог хаягдлын хор уршиг, ангиалан ялгах талаар ажилтнуудад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны турш	2024 онд	-	-	Салбарын дарга, БО-ны мэргэжилтэн	Хог хаягдлын сургалтыг төлөвлөгөөний дагуу орсон. Хог хаягдлын бүртгэлийг бүртгэлийг цахим байдлаар бүртгэж, дагалдах бичгийг тогтмол үйлдэн архивлаж байна.
7	Үндсэн үйл ажиллагаатай холбогдон гарч болзошгүй бусад зардал	-	2024 онд	-	-	Салбарын дарга	
Нийт зардал					₮ 16,600,000.00		

Зураг 22. Ажлын хувцас хэрэгсэл, НБХХ



Зураг 22. Эрүүл мэндийн үзлэг



**ХІ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ,
СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
1	БОАЖЯам	Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган БОАЖЯам-нд хүргүүлнэ.	БОМТ-ний хэрэгжилтийн тайлан гүйцэтгэл	Жил бүрийн 11-р сарын 1-ний дотор илгээх	БОМТ-ний хэрэгжилтийн тайланг хүлээн авч дүгнэлт гаргаж, дараагийн жилд хэрэгжүүлэх БОМТ-г хянан батална.	БО-ны мэргэжилтэн	“МЕРА” ХХК
2	Төсөл хэрэгжих сумын засаг дарга, Багийн засаг дарга	Хагас жилийн тайланг хүргүүлж санал авах	Төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн ажлуудын мэдээлэл	Хагас жил тутам	Тухайн жилийн БОМТ, түүний хэрэгжилт	Салбарын дарга	
3	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч						
4	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн багийн ИНХ	Танилцуулга хийх	БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулга	Хагас жил тутам	БОМТ-ний хэрэгжилтийг танилцуулж, санал авах	Салбарын дарга, БО мэргэжилтэн	
5	Иргэд, олон нийт/ дурын оролцогч, сонирхогч талууд	Санал хүсэлт хүлээн авч, төсөлтэй холбогдох гомдлыг шийдвэрлэж, барагдуулах	МЕРА ХХК-ийн үйл ажиллагаа, БО хамгаалах чиглэлээр хийж гүйцэтгэж буй ажил, орон нутгийн хамтын ажиллагааны талаар	Төсөл хэрэгжих бүхий л хугацаанд	Сонирхогч, оролцогч талуудыг хүссэн мэдээллээр хангах	Салбарын дарга	